# ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

# 2024 I-IX

2024 оны 10 сарын 20 өдөр

# ГАРЧИГ

1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ..... 1
1.1. Эрдэс бүтээгдэхүүний экспортын төсөөлөл, гүйцэтгэл ..... 1
1.2. Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл ..... 1
1.3. Уул уурхай, олборлох салбарын төсөвт төвлөрүүлсэн орлого ..... 3
2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР ..... 4
2.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ..... 4
2.1.1. Уул уурхай, олборлох салбар ..... 4
2.1.2. Хүнд үйлдвэрийн салбар ..... 4
2.1.3. Газрын тосны салбар ..... 4
2.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл ..... 6
2.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн ..... 7
3. ГАДААД ХУДАЛДАА ..... 8
3.1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт ..... 8
3.1.1. Уул уурхай, олборлох салбар ..... 8
3.1.2. Газрын тосны салбар ..... 9
3.1.3. Хүнд үйлдвэрийн салбар ..... 10
3.2. Эрдэс бүтээгдэхүүний импорт ..... 10
3.2.1. Газрын тосны салбар ..... 10

# 1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ

## 1.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨСӨӨЛӨЛ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр баталсан **МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИАР** Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ,
ГҮЙЦЭТГЭЛ (БИЕТ ХЭМЖЭЭГЭЭР)

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2024 | | Зөрүү | Гүйцэтгэл хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | I-IX | | |
| 1 | Нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх | мян.тн | 78,100.0 | 61,225.2 | 16,874.8 | 78.4% |
| 2 | Зэсийн баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх | мян.тн | 1,560.0 | 1,186.4 | 373.6 | 76.0% |
| 3 | Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх | мян.тн | 8,400.0 | 5,461.4 | 2,938.6 | 65.0% |
| 4 | Алтны олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх (МБ-нд тушаасан)[1] | тн | 18.0 | 12.2 | 5.8 | 67.9% |
| 5 | Газрын тосны экспортын хэмжээг нэмэгдүүлэх | мян.бар | 4,850.0 | 3,099.8 | 1,750.2 | 63.9% |
| 6 | Цайрын хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх[2] | мян.тн | 100.0 | 91.9 | 8.1 | 91.9% |
| 7 | Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх[3] | мян.тн | 800.0 | 918.9 | (118.9) | 114.9% |

Эх сурвалж: СЯ, ГЕГ, МБ

## 1.2. ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2024 оны эхний 9 сарын байдлаар 22,758.8 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 5,105.7 (28.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Үүнээс, Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого 7,881.1 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1,672.8 (26.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулав.

- Уул уурхай, олборлох — 7,680.7 тэрбум төгрөг буюу 33.7 хувь,
- Газрын тос — 132.1 тэрбум төгрөг буюу 0.6 хувь,
- ТЗ-ийн төлбөр — 29.2 тэрбум төгрөг буюу 0.1 хувь,
- Бусад орлого — 39.1 тэрбум төгрөг буюу 0.2 хувь.

[1] Монголбанкны үнэт металл худалдан авалтын мэдээлэл болно.
[2] Цайр нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно
[3] Хайлуур жонш нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад тусгагдаагүй заалт болно.

Эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 34.6 хувийг бүрдүүлж байна.

### УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО, тэрбум төгрөгөөр

| № | Үзүүлэлт | Гүйцэтгэл / I-IX / | | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|---|
| | | 2023 | 2024 | +/- | Хувь |
| Нийт орлогын дүн | | 6,208.2 | 7,881.1 | 1,672.8 | 26.9% |
| УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР | | | | | |
| Нийт дүн | | 5,914.2 | 7,680.7 | 1,766.5 | 29.9% |
| 1 | Алт | 205.3 | 266.6 | 61.3 | 29.9% |
| 2 | Зэс | 1,763.2 | 1,697.2 | -66.0 | -3.7% |
| 3 | Нүүрс | 3,649.8 | 5,326.6 | 1,676.8 | 45.9% |
| 4 | Төмөр | 67.3 | 105.8 | 38.5 | 57.2% |
| 5 | Цайр | 118.2 | 61.6 | -56.6 | -47.9% |
| 6 | Хайлуур жонш | 14.8 | 34.8 | 20.0 | 2.4[1] |
| 7 | Бусад | 95.6 | 188.1 | 92.5 | 96.7% |
| ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР | | | | | |
| 8 | Газрын тос | 224.2 | 132.1 | -92.1 | -41.1% |
| ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БОЛОН БУСАД ОРЛОГО | | | | | |
| Нийт дүн | | 69.9 | 68.3 | -1.6 | -2.2% |
| 9 | Тусгай зөвшөөрлийн төлбөр | 28.4 | 29.2 | 0.8 | 2.8% |
| 10 | УТ-ийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр | 1.1 | 1.4 | 0.3 | 25.7% |
| 11 | Төсөвт байгууллагын өөрийн орлого /СШ-ын орлого/ | 36.5 | 35.3 | -1.3 | -3.4% |
| 12 | Бусад орлого | 3.8 | 2.4 | -1.4 | -36.7% |

Эх сурвалж: СЯ, АМГТГ

Тайлбар: 1 – дахин их

## 1.3. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

2024 оны эхний 9 сарын байдлаар улсын төсөвт 7,680.7 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Нүүрс 5,326.6 тэрбум төгрөг,
- Зэс 1,697.2 тэрбум төгрөг,
- Алт 266.6 тэрбум төгрөг,
- Төмөр 105.8 тэрбум төгрөг,
- Цайр 61.6 тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 34.8 тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал 188.1 тэрбум төгрөг.

Уул уурхай, олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 1,766.5 (29.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Нүүрс 1,676.8 (45.9%) тэрбум төгрөг,
- Алт 61.3 (29.9%) тэрбум төгрөг,
- Төмөр 38.5 (57.2%) тэрбум төгрөг,
- Хайлуур жонш 20.0 (2.4 дахин) тэрбум төгрөг,
- Бусад 92.5 (96.7%) тэрбум төгрөг.

Харин дараах ашигт малтмалын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй гарсан байна. Үүнд:

- Зэс 66.0 (3.7%) тэрбум төгрөг,
- Цайр 56.6 (47.9%) тэрбум төгрөг.

# 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

## 2.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

### 2.1.1. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР

2024 оны эхний 9 сарын байдлаар 72,204.7 мян.тн нүүрс, 1,103.7 мян.тн зэсийн баяжмал, 4,005.7 тн молибдены баяжмал, 9,550.2 кг алт, 4,623.9 мян.тн төмрийн хүдэр, 2,605.3 мян.тн төмрийн хүдрийн баяжмал, 295.3 мян.тн хайлуур жоншны хүдэр, 82.1 мян.тн хайлуур жоншны баяжмал, 399.0 мян.тн цайрын баяжмал, 12,961.2 тн мөнгөний баяжмал үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс 15,788.4 (28.0%) мян.тн, зэсийн баяжмал 52.9 (5.0%) мян.тн, төмрийн хүдэр 851.4 (22.6%) мян.тн, төмрийн баяжмал 802.3 (44.5%) мян.тн, хайлуур жоншны хүдэр 85.2 (40.6%) мян.тн, цайрын баяжмал 113.9 (39.9%) мян.тн, мөнгөний баяжмал 1,497.8 (13.1%) тн-оор тус тус өссөн байна.

Харин молибдены баяжмал 218.9 (5.2%) тн, алт 1,324.1 (12.2%) кг, хайлуур жоншны баяжмал 44.0 (34.9%) мян.тн-оор тус тус буурсан байна.

### 2.1.2. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

2024 оны эхний 9 сарын байдлаар 6,225.1 мян.тн баяжуулсан нүүрс, 316.1 мян.тн нүүрсэн шахмал түлш, 4,754.5 тн катодын зэс, 26,335.0 тн металл бэлдэц, 24,908.8 тн металл цувимал, 4,245.0 тн ган төмөр хийц тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад баяжуулсан нүүрс 1,095.9 (21.4%) мян.тн-оор өссөн байна.

Харин нүүрсэн шахмал түлш 9.7 (3.0%) мян.тн, катодын зэс 2,605.1 (35.4%) тн, металл бэлдэц 536.8 (2.0%) тн, металл цувимал 920.2 (3.6%) тн, ган төмөр хийц 402.5 (8.7%) мян.тн-оор тус тус буурсан байна.

### 2.1.3. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

2024 оны эхний 9 сарын байдлаар 3,149.4 мян.бар газрын тос үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 557.2 (15.0%) мян.бар-иар буурсан байна.

## АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

| № | Бүтээгдэхүүний төрөл | Хэмжих нэгж | 2023 | | 2024 | | Өөрчлөлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | IX | I-IX | IX | I-IX | (5-3)=?, (5/3)=% | | (6-4)=?, (6/4)=% | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1. Уул уурхай, олборлолт | | | | | | | | | | |
| 1.1 | Нүүрс | мян.тн | 7,966.3 | 56,416.3 | 8,107.7 | 72,204.7 | 141.5 | 1.8% | 15,788.4 | 28.0% |
| 1.2 | Газрын тос | мян.бар | 409.9 | 3,706.6 | 331.2 | 3,149.4 | -78.7 | -19.2% | -557.2 | -15.0% |
| 1.3 | Зэсийн баяжмал, ме/агуулгаар | мян.тн | 103.3 | 1,050.7 | 137.0 | 1,103.7 | 33.7 | 32.7% | 52.9 | 5.0% |
| 1.4 | Молибдений баяжмал, ме/агуулгаар | тн | 475.9 | 4,224.6 | 485.9 | 4,005.7 | 10.0 | 2.1% | -218.9 | -5.2% |
| 1.5 | Цэвэршүүлээгүй алт | кг | 1,493.9 | 10,874.3 | 1,375.2 | 9,550.2 | -118.8 | -8.0% | -1,324.1 | -12.2% |
| 1.6 | Төмрийн хүдэр, баяжмал: | | | | | | | | | |
| | Төмрийн хүдэр | мян.тн | 660.6 | 3,772.5 | 487.9 | 4,623.9 | -172.7 | -26.1% | 851.4 | 22.6% |
| | Төмрийн хүдрийн баяжмал | мян.тн | 275.2 | 1,803.0 | 401.6 | 2,605.3 | 126.5 | 46.0% | 802.3 | 44.5% |
| 1.7 | Хайлуур жоншны хүдэр, баяжмал: | | | | | | | | | |
| | Хайлуур жоншны хүдэр | мян.тн | 36.1 | 210.1 | 46.9 | 295.3 | 10.8 | 29.9% | 85.2 | 40.6% |
| | Хайлуур жоншны баяжмал | мян.тн | 21.9 | 126.1 | 7.8 | 82.1 | -14.1 | -64.4% | -44.0 | -34.9% |
| 1.8 | Цайрын баяжмал | мян.тн | 39.0 | 285.1 | 50.8 | 399.0 | 11.8 | 30.1% | 113.9 | 39.9% |
| 1.9 | Мөнгөний баяжмал | тн | 1,279.6 | 11,463.4 | 1,082.3 | 12,961.2 | -197.3 | -15.4% | 1,497.8 | 13.1% |
| 2. Боловсруулах үйлдвэр | | | | | | | | | | |
| 2.1. Хүнд үйлдвэр | | | | | | | | | | |
| 2.1.1 | Баяжуулсан нүүрс | мян.тн | 602.1 | 5,129.1 | 555.1 | 6,225.1 | -47.1 | -7.8% | 1,095.9 | 21.4% |
| 2.1.2 | Нүүрсэн шахмал түлш | мян.тн | 51.8 | 325.8 | 47.9 | 316.1 | -3.8 | -7.4% | -9.7 | -3.0% |
| 2.1.3 | Катодын зэс | тн | 799.7 | 7,359.7 | 744.3 | 4,754.5 | -55.4 | -6.9% | -2,605.1 | -35.4% |
| 2.1.4 | Металл бэлдэц | тн | 3,332.0 | 26,871.8 | 3,022.9 | 26,335.0 | -309.2 | -9.3% | -536.8 | -2.0% |
| 2.1.5 | Металл цувимал | тн | 3,163.0 | 25,829.0 | 3,051.0 | 24,908.8 | -112.0 | -3.5% | -920.2 | -3.6% |
| 2.1.6 | Ган төмөр хийц | тн | 690.9 | 4,647.5 | 110.4 | 4,245.0 | -580.5 | -84.0% | -402.5 | -8.7% |

Эх сурвалж: ҮСХ

Тайлбар: 1 - дахин их

## 2.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

| Салбар | 2023 | | 2024 | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | IX | I-IX | IX | I-IX | (5-3)=?, (5/3)=% | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Нийт дүн** | **2,643.9** | **21,623.6** | **2,607.6** | **23,685.4** | **2,061.8** | **9.5%** |
| **Уул уурхай, олборлолт** | **1,855.3** | **15,184.1** | **1,818.4** | **17,057.9** | **1,873.8** | **12.3%** |
| Чулуун, хүрэн нүүрс олборлолт | 934.0 | 6,225.2 | 732.5 | 8,017.4 | 1,792.2 | 28.8% |
| Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт | 121.9 | 981.4 | 84.0 | 856.0 | -125.4 | -12.8% |
| Металлын хүдэр олборлолт | 762.1 | 7,726.3 | 965.5 | 7,880.4 | 154.1 | 2.0% |
| Бусад ашигт малтмал олборлолт | 31.6 | 211.7 | 31.9 | 259.0 | 47.3 | 22.4% |
| Уул уурхайн туслах үйл ажиллагаа | 5.7 | 39.6 | 4.5 | 45.2 | 5.6 | 14.2% |
| **Боловсруулах үйлдвэр** | **642.0** | **4,959.2** | **632.1** | **5,012.8** | **53.6** | **1.1%** |
| **Үнээс, хүнд үйлдвэр** | **183.0** | **1,228.1** | **195.1** | **1,236.7** | **8.6** | **0.7%** |
| Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 27.3 | 166.6 | 27.1 | 123.5 | -43.0 | -25.8% |
| Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 0.5 | 4.2 | 0.7 | 3.9 | -0.3 | -7.7% |
| Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 0.5 | 6.2 | 0.3 | 3.8 | -2.3 | -38.0% |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 85.8 | 494.7 | 92.5 | 506.6 | 11.9 | 2.4% |
| Металл боловсруулах үйлдвэрлэл | 41.0 | 309.8 | 49.0 | 366.0 | 56.1 | 18.1% |
| Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 3.7 | 30.7 | 3.6 | 25.9 | -4.9 | -15.9% |
| Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл | 0.5 | 4.3 | 0.6 | 5.1 | 0.8 | 17.4% |
| Бусад боловсруулах үйлдвэрлэл | 23.8 | 211.5 | 21.2 | 201.9 | -9.6 | -4.5% |

Эх сурвалж: ҮСХ

Тайлбар: 1 - дахин их

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 9 сарын байдлаар 23.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.1 (9.5%) их наяд төгрөгөөр өссөн байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 17.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (12.3%) их наяд төгрөгөөр өсөхөд чулуун, хүрэн нүүрс олборлолт 1.8 (28.8%) их наяд төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 154.1 (2.0%) тэрбум төгрөгөөр, бусад ашигт малтмал олборлолт 47.3 (22.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

Харин газрын түүхий тос, байгалийн хий олборлолт 125.4 (12.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар 72.0 хувийг эзэлж байна.

## 2.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

| Салбар | 2023 | | 2024 | | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | IX | I-IX | IX | I-IX | Гад-д | (5-3)=?, (5/3)=% | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Нийт дүн** | **4,147.3** | **33,925.6** | **4,246.1** | **37,756.5** | **27,579.5** | **3,831.0** | **11.3%** |
| **Уул уурхай, олборлолт** | **3,229.5** | **26,193.5** | **3,302.2** | **30,134.2** | **26,854.1** | **3,940.7** | **15.0%** |
| Чулуун, хүрэн нүүрс олборлолт | 1,990.9 | 14,920.3 | 1,674.0 | 17,995.1 | 16,745.7 | 3,074.8 | 20.6% |
| Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт | 114.7 | 941.3 | 85.3 | 837.5 | 837.5 | -103.8 | -11.0% |
| Металлын хүдэр олборлолт | 1,073.2 | 9,948.0 | 1,486.9 | 10,857.7 | 8,950.1 | 909.6 | 9.1% |
| Бусад ашигт малтмал олборлолт | 45.0 | 344.3 | 51.4 | 398.7 | 320.8 | 54.5 | 15.8% |
| Уул уурхайн туслах үйл ажиллагаа | 5.7 | 39.6 | 4.5 | 45.2 | | 5.6 | 14.2% |
| **Боловсруулах үйлдвэр** | **770.6** | **6,244.7** | **786.5** | **6,002.1** | **725.4** | **-242.6** | **-3.9%** |
| **Үүнээс, хүнд үйлдвэр** | **215.3** | **1,434.8** | **208.8** | **1,409.1** | **206.4** | **-25.7** | **-1.8%** |
| Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 5.9 | 50.8 | 4.1 | 44.4 | 1.1 | -6.4 | -12.6% |
| Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 0.5 | 4.5 | 0.7 | 4.1 | | -0.5 | -10.5% |
| Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 0.4 | 5.7 | 4.4 | 9.9 | | 4.2 | 72.4% |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 116.4 | 694.9 | 120.7 | 687.8 | | -7.0 | -1.0% |
| Металл боловсруулах үйлдвэрлэл | 60.6 | 403.8 | 50.7 | 413.9 | 192.5 | 10.1 | 2.5% |
| Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 4.3 | 29.9 | 5.1 | 30.6 | 12.8 | 0.7 | 2.2% |
| Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл | 0.6 | 5.4 | 0.8 | 6.2 | | 0.8 | 15.0% |
| Бусад боловсруулах үйлдвэрлэл | 26.6 | 239.7 | 22.5 | 212.2 | | -27.5 | -11.5% |

Эх сурвалж: ҮСХ

Тайлбар: 1 - дахин их

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2024 оны эхний 9 сарын байдлаар 37.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.8 (11.3%) их наяд төгрөгөөр өссөн байна. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 30.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.9 (15.0%) их наяд төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолтын салбарын борлуулалт 3.1 (20.6%) их наяд төгрөг, металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 909.6 (9.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлөв.

Харин газрын тосны олборлолтын салбарын борлуулалт 103.8 (11.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс 27.6 их наяд төгрөг буюу 73.0 хувийг гадаад зах зээлд борлуулсан байна. Гадаад зах зээлд борлуулсан нийт бүтээгдэхүүний 26.9 их наяд төгрөг буюу 97.4 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн эзэлж байна.

## 3. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны эхний 9 сарын байдлаар 20,390.9 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2,339.3 (13.0%) сая ам.доллараар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж 3,174.4 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

### 3.1. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

Нийт экспорт 2024 оны эхний 9 сарын байдлаар 11,782.7 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 486.5 (4.3%) сая ам.доллараар өссөн байна.

Үүнээс: Эрдэс бүтээгдэхүүний экспорт 11,048.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 679.3 (6.6%) сая ам.доллараар өссөн байна.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жонш, молибдены баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, мөнгө, тунгаасан зэс ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 93.8 хувийг эзэлж байна.

ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ДУНДАЖ ҮНЭ

| Барааны нэр | Хэмжих нэгж | 2023 | 2024 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | I-IX | | Өсөлт/бууралт | Хувь |
| Чулуун нүүрс | тн/ам.дол | 137.0 | 112.5 | -24.5 | -17.9% |
| Зэсийн баяжмал | тн/ам.дол | 1,737.0 | 1,908.7 | 171.7 | 9.9% |
| Төмрийн хүдэр, баяжмал | тн/ам.дол | 76.3 | 81.8 | 5.5 | 7.2% |
| Цайрын баяжмал | тн/ам.дол | 1,487.8 | 1,434.9 | -52.9 | -3.6% |
| Хайлуур жоншны хүдэр, баяжмал | тн/ам.дол | 252.8 | 233.8 | -19.0 | -7.5% |
| Молибдены баяжмал | тн/ам.дол | 20,155.3 | 15,666.8 | -4,488.5 | -22.3% |
| Алт | кг/ам.дол | 62,483.7 | 74,495.4 | 12,011.6 | 19.2% |

Эх сурвалж: ГЕГ

Тайлбар: 1 - дахин их

#### 3.1.1. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАР

Нүүрсний экспорт: 2024 оны эхний 9 сарын байдлаар 6,736.7 сая ам.долларын 61,225.2 мян.тн нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 218.6 (3.4%) сая ам.доллараар, биет хэмжээгээр 12,301.1 (25.1%) мян.тн-оор тус тус өссөн байна. Нүүрсний 100.0 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Зэсийн баяжмалын экспорт: 2024 оны эхний 9 сарын байдлаар 2,264.4 сая ам.долларын 1,186.4 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 264.6 (13.2%) сая ам.доллараар, биет хэмжээгээр 35.1 (3.0%) мян.тн-оор тус тус өссөн байна. Зэсийн баяжмалын 100.0 хувийг БНХАУ руу экспортолсон байна.

Төмрийн хүдэр, баяжмалын экспорт: 2024 оны эхний 9 сарын байдлаар 446.7 сая ам.долларын 5,461.4 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 123.1 (38.0%) сая ам.доллараар, биет хэмжээгээр 1,221.1 (28.8%) мян.тн-оор тус тус өссөн байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Хайлуур жоншны хүдэр, баяжмалын экспорт: 2024 оны эхний 9 сарын байдлаар 214.8 сая ам.долларын 918.9 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 185.4 (25.3%) мян.тн-оор, үнийн дүнгээр 29.4 (15.8%) сая ам.доллараар тус тус өссөн байна. Хайлуур жоншны хүдэр, баяжмалын 83.9 хувийг БНХАУ, 15.8 хувийг ОХУ руу тус тус экспортолсон байна.

Цайрын баяжмалын экспорт: 2024 оны эхний 9 сарын байдлаар 131.8 сая ам.долларын 91.9 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 36.9 (28.7%) мян.тн-оор, үнийн дүнгээр 59.8 (31.2%) сая ам.доллараар тус тус буурсан байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Молибдены баяжмалын экспорт: 2024 оны эхний 9 сарын байдлаар 67.3 сая ам.долларын 4,295.3 тн молибдены баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 24.5 (26.7%) сая ам.доллараар, биет хэмжээгээр 261.0 (5.7%) тн-оор тус тус буурсан байна. Молибдены баяжмалын 78.0 хувийг БНХАУ, 22.0 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

Алтны экспорт: 2024 оны эхний 9 сарын байдлаар 670.5 сая ам.долларын 9,000.8 кг алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 109.7 (19.6%) сая ам.доллараар, биет хэмжээгээр 25.8 (0.3%) кг-аар тус тус өссөн байна. Алтны 76.4 хувийг Швейцар, 23.2 хувийг АНУ руу тус тус экспортолсон байна.

### 3.1.2. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

Газрын тосны экспорт: 2024 оны эхний 9 сарын байдлаар 248.9 сая ам.долларын 3,099.8 мян.бар газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 457.6 (12.9%) мян.бар-иар, үнийн дүнгээр 22.1 (8.2%) сая ам.доллараар тус тус буурсан байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

### 3.1.3. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Коксын экспорт: 2024 оны эхний 9 сарын байдлаар 783.3 мян.ам.долларын 7.6 мян.тн кокс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 9.6 (92.4%) сая ам.доллараар, биет хэмжээгээр 55.5 (87.9%) мян.тн-оор тус тус буурсан байна.

Катодын зэс: 2024 оны эхний 9 сарын байдлаар 81.1 сая ам.долларын 9,171.6 тн катодын зэс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 91.2 (1.0%) тн-оор, үнийн дүнгээр 5.5 (7.2%) сая ам.доллараар тус тус өссөн байна.

## 3.2. ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

Нийт импорт 2024 оны эхний 9 сарын байдлаар 8,608.3 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1,852.8 (27.4%) сая ам.доллараар өссөн байна.

Үүнээс, Эрдэс бүтээгдэхүүний импорт 1,835.2 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 265.0 (16.9%) сая ам.доллараар өссөн байна.

ЭРДЭС БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТЫН ДУНДАЖ ҮНЭ

| Барааны нэр | Хэмжих нэгж | 2023 | 2024 | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| | | I-IX | | Өсөлт/бууралт | Хувь |
| Автобензин | тн/ам.дол | 713.8 | 717.2 | 3.4 | 0.5% |
| Дизель түлш | тн/ам.дол | 782.2 | 802.4 | 20.2 | 2.6% |

Эх сурвалж: ГЕГ

Тайлбар: 1 - дахин их

### 3.2.1. ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР

Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн 88.4 хувийг газрын тосны бүтээгдэхүүн эзэлж байна.

2024 оны эхний 9 сарын байдлаар 1,622.7 сая ам.долларын 2,016.7 мян.тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 267.1 (15.3%) мян.тн-оор, үнийн дүнгээр 254.3 (18.6%) сая ам.доллараар тус тус өссөн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн 89.5 хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний 28.6 хувийг автобензин, 60.9 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.

Автобензины импорт: 2024 оны эхний 9 сарын байдлаар 464.0 сая ам.долларын 646.9 мян.тн автобензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 85.0 (15.1%) мян.тн-оор, үнийн дүнгээр 62.9 (15.7%) сая ам.доллараар тус тус өссөн байна.

**Дизель түлшний импорт:** 2024 оны эхний 9 сарын байдлаар 988.2 сая ам.долларын 1,231.5 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 187.0 (23.3%) сая ам.доллараар, биет хэмжээгээр 207.1 (20.2%) мян.тн-оор тус тус өссөн байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ